

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2016-5 САР)


Монголбанк, “Тэнхлэг зууч” компанийтай хамтран 2016 оны 5 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 5,006 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

2016 оны 5 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 0.1%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 11.4%-иар тус тус буурчээ.


Тухайн сард зах зээл дээр өндөр өртөг бүхий шинэ орон сууц нийлүүлэгдсэнтэй холбоотойгоор шинэ орон сууцны үнэ өмнөх сараас бага зэрэг өссөн ч хуучин орон сууцны үнэ үргэлжлэн буурсан нь орон сууцны үнийн индексийг бууруулахад нөлөөлжээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХӨТҮН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн утэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хувьэр байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



Жишээ: БЗД-ийн “Баянзүрх” хотхонд 2015 оны 5 дугаар сард 1 м² дундаж үнэ 1,613,000 төгрөг байсан бол 2016 оны 5 дугаар сарын байдлаар 1,411,000 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.5%-иар буурсан байна.


1. Шинэ орон сууцны үнэ¹

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2016 оны 5 дугаар сарын байдлаар 2,040,000 төгрөг болж өмнөх сараас 0.7 хувиар өссөн бол, өнгөрсөн оны мөн үеэс 6.1 хувиар буурсан байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2016.5/


Орон сууцны дундаж үнэ	2,040,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-6.1%
Сарын өсөлтийн хувь	0.7%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр²

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ³ нь 2016 оны 5 дугаар сарын байдлаар 79,869,000 төгрөг болж өмнөх сараас 0.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 15.3 хувиар тус тус буурсан байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2016.5/


Орон сууцны дундаж үнэ	79,869,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-15.3%
Сарын өсөлтийн хувь	-0.2%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сая.төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

² Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцаангуй их.

³ 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)

¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.